



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/211

Сүхбаатар сум

### Зарцуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.5, Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодсх бүртгэлд тусгах, хяналт тавих" журмын 3.1.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн, төсвийн шаардлагатай зардал болон алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зардалд захиран зарцуулахыг Биеийн тамир, спортын газрын дарга У.Батмөнхөд зөвшөөрсүгэй.

2. Холбогдох журмын дагуу зарцуулалтын эрхийн баталгааг нээж олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг зарцуулсан тайланг холбогдох журмын дагуу тайлагнахыг Биеийн тамир, спортын газар /У.Батмөнх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ